



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№171 /381/

2022.09.26

Цаг үе, үйл явдал

ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Монгол Улсын Зэвсэгт хүчнээс Бүгд Найрамдах Өмнөд Судан Улс дахь "UNMISS" энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх XII ээлжийн цэргийн багийн ажиллагааны өмнөх сургалт, бэлтгэлийн хүрээнд тус батальоны даргалах албан тушаалын ахлагч нартай сургагч багшийн дамжааг 9 дүгээр сарын

14-20-ны өдрүүдэд, цэргийн гал тогооны тогооч, бэлтгэгч нарын чадавхжуулах сургалтыг 9 дүгээр сарын 14-22-ны өдрүүдэд Энхийг дэмжих ажиллагааны сургалтын төвийг түшиглэн тус тус зохион байгууллаа.

Сургалт, бэлтгэлийн чанарыг дээшлүүлж, үр өгөөжтэй байлгах үүднээс ЗХЖШ-ын Ар

талын газрын Материал хангалтын хэлтэс, Монголын тогооч нарын холбооны дэргэдэх "Залуу мастер" сургалтын төвийн мастер тогооч, багш нартай хамтран тогооч, бэлтгэгч нарт гурван үе шаттай нийт 102 цагийн сургалтыг онол, дадлага хэлбэрээр хослуулан явуулав.

Цэргийн багийн

ажиллагааны өмнөх сургалтад сургагч багш нар хичээл зааж, давтлага явуулснаар бие бүрэлдэхүүний сургалтын чанарт ахиц гарч, дадлага, чадвар нэмэгдэх ач холбогдолтой гэдгийг холбогдох албаны хүмүүс онцолсон юм.

Хэвлэлийн төлөөлөгч ахлах дэслэгч Л.ТҮМЭНДЭЛГЭР

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 20	☁️ 2

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 31	☁️ 22

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.415	3.430
EUR 🇪🇺	3.415	3.430
CNY 🇨🇳	486	490
RUB 🇷🇺	53.50	54.50
JPY 🇯🇵	24.20	24.55
KRW 🇰🇷	2.46	2.48

ЗУРХАЙ



2022.09.26/ ДАВАА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 1

НАМРЫН ДУНД САРЫН ШАРАГЧИН ТАХИА САР ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ ХАР МОРЬ ӨДӨР

Үс засуулбал:

Нас ахар болно

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

06.44-19.43

Барилдлага:

Үл зохилдох

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Авахуй

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ АХМАДЫН ХОРОО ХУРАЛДЛАА



Батлан хамгаалах яамнаас ахмад настны талаар баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар дөрвөн жилийн төлөвлөгөөг баталж, Батлан хамгаалахын сайдын дэргэдэх Ахмадын зөвлөлийг байгуулаад буй.

Өнгөрөгч бямба гарагт Офицеруудын ордонд Батлан хамгаалах яамны Ахмадын хороо Удирдах зөвлөлийн анхдугаар хуралдаанаа зохион байгуулан, үйл ажиллагааны тайлангаа илтгэн тулгамдаж буй асуудлаа хэлэлцлээ.

Ахмадын хорооны Хяналтын зөвлөлийн илтгэлийг тус зөвлөлийн дарга чөлөөнд байгаа хурандаа Ч.Батцэрэн танилцуулж БХЯ-ны Ахмадын хорооны санхүү, бусад үйл ажиллагааг "Бүрэн хангалттай" гэж дүгнэв. Ахмадын хорооны Удирдах зөвлөлийн даргаар чөлөөнд байгаа хошууч генерал Д.Магсаржавыг улируулан ажиллуулахаар шийдвэрлэв.

Ахмадын хорооны Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд чөлөөнд байгаа дэд хурандаа Ш.Нанзад, С.Цэндбаатар, Ш.Баяраа,

П.Цэцэгмаа, Ц.Цэцэгээ нарыг улируулан сонгож өөрийн хүсэлтээр нэрээ татсан чөлөөнд байгаа хурандаа Ц.Энхбат, Л.Оюунцэцэг, О.Оюунбат нарын оронд чөлөөнд байгаа хурандаа Ц.Энхбаатар, Л.Батаа, энгийн Ч.Амарсанаа нарыг нөхөн сонголоо. Түүнчлэн Хяналтын зөвлөлийг улируулан ажиллуулахаар баталж гишүүн чөлөөнд байгаа дэд хурандаа Ш.Цэгмидийн оронд чөлөөнд байгаа хошууч Ц.Баатаржамцыг нөхөн сонгосон юм. Хурлын төгсгөлд Ардын

хувьсгалын 100 жилийн ойн медаль, БХЯ-ны Жуух бичиг, "Эх орны төлөө" медалиар зарим ахмад настанг шагналаа. Мөн ЦДБЭЧ-ын уран бүтээлчид шилдэг бүтээлийн дээжсээ өргөн толилуулав. Монгол Улсын Засгийн газраас 1992 оноос эхлэн ахмад настнууддаа жил бүрийн 10 дугаар сарын 1-ний өдөр хүндэтгэл үзүүлдэг уламжлалтай тогтсон бөгөөд Монгол Улсын хэмжээнд Ахмадын баярыг 29 дэх жилдээ тэмдэглэн өнгөрүүлэх гэж байна. **Х.УНДАРМАА**



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 620,302,498

Эдгэрсэн

Нийт: 600,498,840

Нас барсан

Нийт: 6,540,425

ЦАХИМ ШУУДАНД

ОТГОНТЭНГЭР ИХ СУРГУУЛЬД СУРАЛЦАХЫГ УРЬЖ БАЙНА

Эх орноо батлан хамгаалах эр цэргийн албаа хааж идэр залуу насныхаа эрч хүчийг хурцалж ирээдүй хойчийн замыг засаж “хал” цэргийн хувцас гангараагаа бэлтгэж байгаа та нартаа итгэмжлэн хүргэх зар мэдээ байна.

Гурав дахь удаагаа магадлан итгэмжлэгдсэн Отгонтэнгэр их сургууль нийгмийн хариуцлагын хүрээнд энэ жил цэргийн албанаас халагдаж буй залууст дараах боломжийг олгож байна.

1. Халагдсан даруйдаа Отгонтэнгэр их сургуульд элсэн суралцаж жил алдахгүй төгсөх
2. Эхний жил үнэ төлбөргүй буюу 100 хувийн хөнгөлөлттэй суралцах
3. ЭЕШ-д бэлтгэх сургалтад үнэ төлбөргүй хамрагдан, шалгалтын талаар зөвлөгөө мэдээлэл авах

Отгонтэнгэр их сургуулийн хөтөлбөрт элсэгч нь Дотоод хэргийн их сургуультай хамтарсан 4+2 хөтөлбөрт хамрагдан хос дипломтой төгсөх боломжтой.

Бүртгүүлэхдээ дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

1. Иргэний үнэмлэх
2. Бүрэн дунд боловсролын үнэмлэх
3. Цэргийн үүрэгтний үнэмлэх

Элсэхийг хүсэгчид 11 сарын 01 дотор ОТИС дээр биечлэн ирж бүртгүүлэх эсвэл ОТИС-ийн Сургалтын албатай холбогдон цахимаар бүртгүүлж болно.

Холбогдох утас: 99882882, 99120889

ОТГОНТЭНГЭР ИХ СУРГУУЛИЙН ГАВЬЯАТ БАГШ, БЭЛТГЭЛ ДЭД ХУРАНДАА, ДОКТОР, ПРОФЕССОР Б.ГАЛИНДЭВ

БАХАРХАЛ

УУЛЧИН ДАЙЧИД ЭХ ОРОНЧ ҮЗЛИЙГ ТҮГЭЭХ ЗОРИЛГООР АЛТАН СОЁМБО БҮТЭЭЖЭЭ



Зэвсэгт хүчний 331 дүгээр ангийн алба хаагчид орон нутагтаа цэрэг-эх оронч үзлийг түгээн дэлгэрүүлэх, сэтгэл түгээн байдалд нь нөлөөлөх зорилгоор Баян-Өлгий аймгийн Бөхөн уулнаа 42 метр урт, 24 метрийн өргөнтэй алтан соёмбыг бүтээсэн байна.

Алтан соёмбыг тус ангийн Уулын нэгдүгээр ротын ажиллагааны офицер, ахлах дэслэгч Б.Даваадоржоор ахлуулсан 15 цэргийн алба хаагч 9 хоногийн хугацаанд гүйцэтгэжээ. Энэхүү бүтээл нь барилгаар жишвэл 15 давхар орон сууцтай дүйцэх бөгөөд алтан соёмбынхоо хүрээг төмрөөр зангидаж, 20 гаруй тонн нутгийн чулуугаар дүүргэсэн байна. Нутгийн иргэд уулчин дайчдыг алтан соёмбо бүтээсэнд талархал илэрхийлж, цэрэг-эх оронч үзлийг түгээсэн бодит ажил боллоо хэмээн онцолжээ.

АХМАД Д.БОЛОР

ЦЭРГИЙН ТАНГАРАГ ӨРГӨЛӨӨ



Бэлтгэл үүрэгтэн буюу цэргийн чухал мэргэжлийн бэлтгэл офицерын 2 дугаар шатны сургалтад хамрагдсан бүрэлдэхүүн өнгөрөгч долоо хоногт ҮБХИС-ийн байрлалд Цэргийн тангараг өргөлөө.

Тус сургалт нь гурван шаттай явагдах бөгөөд нэгдүгээр шатны сургалт нь хоёр сарын хугацаанд цахим хэлбэрээр зохион байгуулагджээ. Харин хоёрдугаар шатны сургалтаар 8 төрлийн нийт 164 цагийн багц хичээлийг судалсан байна. Бэлтгэл офицерын сургалтад хамрагдсан бие бүрэлдэхүүнд гуравдугаар шатны буюу хээрийн дадлага сургуулилтад хамрагдсаны дараа ЗХЖШ-ын даргын тушаалаар бэлтгэл дэслэгч цол олгох аж.

Бэлтгэл дэд түрүүч Г.Буянжаргал: ЦЭРГИЙН АЛБА НАМАЙГ ХҮССЭН МЭРГЭЖИЛТЭЙ МИНЬ ХОЛБОЛОО



Хугацаат цэргийн албаа хаангаа цахимаар их, дээд сургуульдаа суралцах, өөрийгөө бэлтгэж Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрүүдэд болон их дээд сургуулиудын шалгалтуудад оролцож, шалгарах зэрэг олон боломж байдгийг хугацаат албаны зарим дайчин өөрсдийн хичээл, зүтгэлээрээ бусад нөхдөдөө үлгэрлэн харуулсаар байна.

Үүний нэг нь Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн дэд түрүүч Г.Буянжаргал бөгөөд тэрээр цэргийн алба хааж байх хугацаандаа Хөдөө аж ахуйн Их сургуулийн элсэлтэд өөрийгөө бэлтгэж, малын их эмч мэргэжлээр суралцахаар шалгалт өгөхөд тэнцсэн юм. Өдгөө дэд түрүүч Г.Буянжаргал бэлтгэлээр халагдаж, хүссэн сургуульдаа

суралцаж байна. Энэ тухай сэтгэгдлээ хуваалцахдаа “Маш их баяртай байна. Цэргийн алба миний хүсэл мөрөөдлийг минь хурцалж, суралцах, шамдахад минь тусаллаа. Магадгүй цэрэгт яваагүй бол малын эмчээр суралцах хүслээ гээж, төлөвлөлт, зохион байгуулалтгүй утсаа ухсан залуу явж байхыг үгүйсгэхгүй.

Ангийн захирагч, хурандаа Г.Эрдэнэбаатар 2021 оны өвөл “Ирэх хавар их сургуульд элсэх хугацаат цэргийн алба хаагчид байвал цэргийн сургалт бэлтгэлийнхээ хажуугаар өөрийгөө бэлтгээрэй. Бид бүх талын дэмжлэг үзүүлнэ” гэж хэлэхээр нь бэлтгэж эхэлсэн юм.

Миний малын эмч болох минь манай гэр бүлийн эрхэлдэг бизнестэй холбоотой. Манайх

амьтны дэлгүүртэй. Өвдөж, зовсон амьтныг эрүүл саруул болгох нь миний багаас олж авсан хүмүүжил. Амьтныг өвдөж зовохог нь харахад хэцүү байдаг. Тэр ч утгаараа малын эмч болох нь сэтгэл зүйгээ дагасан зөв шийдвэр минь юм. Зэвсэгт хүчинд алба хаасан он цагаа хэзээ ч мартахагүй. Баяр талархал, омогшил, бахархлыг хамгаас их мэдэрлээ. Аав ээж, найз нөхөд, ах дүү, хамаатан садан маань “Үндсэн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, цэргийн албаа хаасан жинхэнэ эр хүн” гэж хүндэтгэж байгаа нь маш их таалагдаж байна” гэсэн юм.

Дэслэгч Р.Билэг (Зэвсэгт хүчний 014 дүгээр анги)